



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: [Selenge@audit.gov.mn](mailto:Selenge@audit.gov.mn)  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

**ТҮШИГ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МОНГОЛ АРДЫН НАМД**

2024.08.07 № ТНАГ-2024/13-УСТА-НА-У  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын

- 018020932

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Монгол Ардын намын Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Түшиг сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (...<sup>5</sup> хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Түшиг сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТҮШИГ СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТҮШИГ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**ТҮШИГ СУМЫНХАА ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА**

**Зорилго.** Хүний хөгжлийн нэн тэргүүнд тавьж, сайн засаглалаар оновчтой бодлого тодорхойлон хүн амын амьдралын үе шат бүрд чиглэсэн нийгмийн бодлогыг хэрэгжүүлнэ.

**Зорилтууд.**

1. Хүний хөгжил
2. Хүрээлэн буй орчны хөгжил
3. Хүртээмжтэй төрийн үйлчилгээ
4. Хөгжилд хөтөлсөн үйлдвэржилт

**Нэг. Хүний хөгжил**

**1.1 Хүүхэд бидний ирээдүй**

- 1.1.1 Хүүхдийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, вакцинд тогтмол хамруулж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 1.1.2 Хүмүүжил, сурлага, урлаг, спортын чиглэлээр хүүхэд бүрийг хөгжүүлэх дугуйлан, секц сонгон дугуйлан, нэмэгдүүлж, чанарыг сайжруулна.
- 1.1.3 Эцэг эх, сурагчдад чиглэсэн сургалт нөлөөллийн ажлуудыг эрчимтэй зохион байгуулж, хоорондын ойлголцлыг бий болгох замаар аз жаргалтай эерэг уур амьсгалтай гэр бүлийн тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлыг бодлогоор дэмжин ажиллана.
- 1.1.4 Нүүдлийн болон зуны цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.5 Хүүхдийн цэцэрлэгийн гадна дотно тоглоомын талбайг орчин үеийн шийдлээр тохижуулна.
- 1.1.6 Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.
- 1.1.7 Дотуур байрны бохирын байгууламжийг шинэчлэн хэвийн ажиллах орчныг бүрдүүлнэ.

**1.2 Залуус бидний – итгэл**

- 1.2.1 Спортын холбоодын үйл ажиллагааг идэвхжүүлж, багийн болон оюуны спортоор залуучуудыг хичээллэхийг бүх талаар дэмжиж ажиллана.
- 1.2.2 Малчин залуусыг хөгжүүлэх сургалт, уулзалт зөвлөгөө, урлаг, спортын арга хэмжээг тогтмол хэвшүүлнэ.

- 1.2.3 Залуу боловсон хүчинд зориулсан орон сууцыг төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр барьж, урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр эзэмшүүлж, төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллах орчныг бүрдүүлнэ.

### **1.3 Ахмадууд бидний –бахархал**

- 1.3.1 Ахмадуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хуулийн дагуу дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.2 Ахмадад чиглэсэн үйл ажиллагааг тогтмолжуулж, байнгын дасгал хөдөлгөөн хийх чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, хамтдаа хөгжих нөхцөл бололцоог бүрдүүлнэ.
- 1.3.3 Ахмадуудад зориулан “Алдрын өдөр” өдөрлөг, арга хэмжээг тогтмолжуулна.
- 1.3.4 Ахмад настныг хуулийн дагуу хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжоор ханган ажиллана.


### **Хоёр. Хүрээлэн буй орчныг хөгжил**

#### **2.1 Ая тухтай орчин – Дэд бүтэц, ногоон хөгжил**

- 2.1.1 Үзүүр хошуу хүртэлх зам болон сумын төвийн зам дагуу гудамжийг гэрэлтүүлэгтэй болгож, иргэдийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.1.2 Сумын төвийн камержуулалтыг үргэлжлүүлэн нэмэгдүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.1.3 Хог ачилтын шинэ систем нэвтрүүлж, хогоо ангилан ялгаж хэвшүүлнэ.
- 2.1.4 Хөрсний бохирдлыг бууруулах замаар гэр хорооллын нүхэн жорлонг эко 00-той болгох зорилгоор иргэдийг ногоон зээлд хамрагдахад нь банкнуудтай хамтран ажиллаж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 2.1.5 Сумын төвийн айл өрхүүдийн ундны усанд зориулсан гүний худгийн тоог нэмэгдүүлнэ.
- 2.1.6 Сумын төв доторх авто замыг хатуу хучилттай болгох ажлыг үргэлжлүүлэн, зарим цэгт зөөлөн орц, гарцыг хийнэ.
- 2.1.7 Сумын төвөөс Үзүүр хошуу хүртэл алхалт гүйлтийн зам байгуулж, иргэдийн эрүүл мэнд, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.1.8 Сумын аялал жуулчлалын маршрутыг тогтоож иргэд малчидтай хамтран өв соёл уламжлал орон нутгаа сурталчлах үйлчилгээг бий болгоно.
- 2.1.9 Төр хувийн хэвшил, иргэдийн хамтын оролцоотойгоор “Өнгөлөг гудамж” хөтөлбөрийн цар хүрээг өргөжүүлэн өрх бүрийн хашаа, нийтийн эзэмшлийн гудамж талбайн өнгө үзэмжийг сайжруулна.



- 2.1.10 Зэлтэр голын зэвэг, загасыг хамгаалах ажлыг эрчимжүүлж, зэвэг загас үржүүлэх санал санаачилга гаргасан иргэд аж ахуйн нэгжийг бүх талаар дэмжиж ажиллана.
- 2.1.11 Зэлтэр голын үерийн хамгаалалтын далан байгуулах ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлж, үе шаттайгаар шийдвэрлүүлнэ.



### **3.1 Гурав. Хүртээмжтэй төрийн үйлчилгээ**


#### **Эрүүл хүн эрхэм жаргалтай - Эрүүл мэндийн үйлчилгээ**

- 3.1.1 Сумандаа тогтвор суурьшилтай ажиллаж байгаа эмч, мэргэжилтнүүдийг дэмжин дутагдалтай эмч эрүүл мэндийн ажилтныг бодлогоор дэмжиж ажиллана.
- 3.1.2 Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгийг үргэлжлүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн хоёр жилд тутамд бүрэн хамруулахад эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллана.
- 3.1.3 Суманд нэн шаардлагатай байгаа шүдний кабинетыг байгуулж, тоног төхөөрөмжөөр ханган, шүдний мэргэжлийн эмчийг бэлтгэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэж, иргэдэд чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлнэ.
- 3.1.4 Эрүүл мэндийн болон орчны тандалт нөлөөллийн үнэлгээ хийж, хөрс усны бохирдлыг багасгах цогц арга хэмжээ авснаар эрүүл аюулгүй орчныг бүрдүүлнэ.

#### **3.2 Оюунлаг Түшигчүүд –Боловсрол, соёлын үйлчилгээ**

- 3.2.1 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулна.
- 3.2.2 Бага дунд боловсролын сургалтын чанарт жил бүр хөндлөнгийн хяналт хийж, эцэг эхчүүдэд танилцуулж хэвшүүлнэ.
- 3.2.3 Багшийн ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, мэргэжлийн нэр хүндийг өсгөхийн зэрэгцээ багш нарыг үе шаттайгаар гадаад дотоодод туршлага судлуулж, давтан сургаж, мэргэшүүлэх замаар мэдлэг боловсрол ур чадвар, хариуцлага, харилцааны соёлыг дээшлүүлнэ.
- 3.2.4 Суманд дутагдалтай байгаа мэргэжлээр өөрийн хүсэлтээр шилжин ирж ажиллах багшийг бодлогоор дэмжин ажиллана.
- 3.2.5 Суманд дутагдалтай багш, соёлын урлагийн мэргэжлийн чиглэлээр амжилттай суралцаж байгаа оюутнуудыг төгсөөд орон нутагтаа ирж ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллана.
- 3.2.6 Сумын түүх дурсгалт газруудыг баримтжуулах, хамгаалах орчныг тохижуулах ард иргэдэд түгээн дэлгэрүүлэхэд онцгой анхаарч ажиллана.
- 3.2.7 Үндэсний өв соёлоо уламжлан хадгалах түгээн дэлгэрүүлэх зорилгоор морин хуурын сургалтыг сонгон дугуйлангаар зааж хичээллүүлнэ.

- 3.2.8 Соёлын төвийн барилгыг засаж тохижуулан тоног төхөөрөмжөөр хангах, иргэд ая тухтай орчинд үйлчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 3.2.9 Соёлын төвийг мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангаж, ажилтнуудыг үе шаттайгаар давтан сургаж, мэргэшүүлж, мэдлэг ур чадвар, соёлын үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ.
- 3.2.10 Иргэд, сурагчдыг цана, тэшүүр болон өвлийн спортоор хичээллүүлж, нийтийн бие тамирыг хөгжүүлэх ажлыг бодлогоор дэмжин ажиллана.
- 3.2.11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулагдаж буй спортын болон урлагийн тэмцээн уралдаан, арга хэмжээг бүх талаар дэмжин хамтран ажиллана.



### **Ес. Шударга ёсны засаглал**

#### **3.3 Тэгш хүртээмж - нээлттэй засаглал**

- 3.3.1 Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санал, санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.
- 3.3.2 Төрийн аливаа шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, аливаа хүнд суртлыг арилгана.
- 3.3.3 Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол гэрээ хэлцэл, мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд нээлттэй ил тод болгоно.
- 3.3.4 Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлж, мэдээллийг ил тод шилэн байлгана.
- 3.3.5 Төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг хангаж, цахим хэлэлцүүлгийн технологийг хөгжүүлнэ.
- 3.3.6 Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа ажил арга хэмжээнд хөндлөнгийн болон дотоод хяналтыг чанартай гүйцэтгэж, үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлнэ.
- 3.3.7 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

#### **4.1 Дөрөв.Хөгжилд хөтөлсөн үйлдвэржилт**

##### **Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл – Хөгжлийн тулгуур**

- 4.1.1 Жимс, жимсгэнэ, мөөг зэрэг шинэ нэр төрлийн таримлын тариалалт үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ.
- 4.1.2 Газар тариалангийн усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 4.1.3 Сумын брэнд Халимаг үүлдрийн үхрийн цөм сүргийг тогтвортой өсгөн малчин иргэдэд түгээн дэлгэрүүлэх замаар ашиг шим, үүлдэр угсаа, чанарыг сайжруулна.



- 4.1.4 Мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор малыг эрүүлжүүлэх ажил болон хувийн мал эмнэлгийн байгууллагад хөндлөнгийн хяналыг хэрэгжүүлэн ажиллана.
- 4.1.5 Сумын иргэд үхэр гахай галуу, тахиа, зөгий гэх зэрэг өрхийн аж ахуйн чиглэлээр эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллана.
- 4.1.6 Байгаль, экологи, бэлчээрийн даацтай уялдуулж малын тоо, төрөл, бүтцийн дээд хязгаарыг тогтоох, бэлчээрийн мэрэгч амьтад, шавжтай тэмцэх, малын бэлчээр, хадлан тэжээл, усны хангамж, хүрэлцээг нэмэгдүүлнэ.

#### **4.2 Баялаг бүтээгчид бидний – хөгжил**

- 4.2.1 Түшиг сумын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг бүх талаар дэмжин сургалт, туршлага судлах арга хэмжээ зохион байгуулна.
- 4.2.2 Баялаг бүтээгчид болох өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бүх талаар дэмжинэ.
- 4.2.3 Хариуцлагатай уул уурхайг дэмжин орон нутгийн иргэдийг хуулийн дагуу байгалийн баялгийн ашгийг тэгш хүртээмжтэй хүртэх, нийгмийн хариуцлагын хүрээнд сумын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах асуудлаар хамтран ажиллана.
- 4.2.4 Зэлтэр хилийн боомтыг байнгын ажиллагаатай болгох асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжлан, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

*Түшиг сумын Монгол Ардын Намын хорооноос 2024 оны Түшиг сумын ИТХ-ын сонгуульд оролцохдоо дэвшүүлж байгаа энэхүү хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн зорилтуудыг Түшиг сумын ард иргэд та бид хамтран хэрэгжүүлж, их бүтээн байгуулалтын он жилүүдэд эх орноо аж үйлдвэржүүлж, атар газар эзэмшин хүн ардаа хүнсээр хангах амин чухал хэрэгцээг хангаж ирсэн, ахмад үеийнхээ түүхэн уламжлалыг хадгалж, орчин цагийн шинэ техник технологи, инновацыг нэвтрүүлж хойч үеийнхээ ирээдүйн сайн сайхныг хамтран бүтээхийн төлөө Түшиг сумаа "ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ".*

#### **ТҮШИГ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**